



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 4/520

Арвайхээр

「 Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай 」

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а” дахь заалт, Засгийн газрын 2019 оны 285 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, шалгах, хүлээн авах ажлын хэсгийг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар, сумдын малчдын бэлтгэх өвс, гар тэжээл, хужир шүү болон аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэлтийн хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг 2019 оны 10 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн), оторлох мал сүргийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, угаалга, тарилга, туулгалтад бүрэн хамруулах, тууврын замд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (А.Нямдаваа) нарт даалгасугай.

3. Аймгийн хэмжээнд 2019 онд бэлтгэх хадлан, тэжээлийг өгөгдсөн хуваарийн дагуу бэлтгэж нөөцлөх, өвөл хаврын улирлын бэлчээрийн даацад тохируулан малын тоог бууруулах, малын чанар, сүргийн бүтцийн зохистой харьцаанд тулгуурлан малыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, нөөцийн мах бэлтгэлийн ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир), сум бүр өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж, биелэлтийн үр дүнг тооцож ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Г. ГАНБОЛД

011100912

Аймгийн Засаг даргын 2019 оны...<sup>07</sup>  
дугаар сарын ...<sup>29</sup>...-ны өдрийн <sup>А/Б</sup> дугаар  
захирамжийн хавсралт



**ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ,  
ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн -Аймгийн Засаг даргын орлогч  
Нарийн бичгийн дарга: Б.Цэнгэл-Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө  
аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга  
Гишүүд: С. Цэдэнбалжир -Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө  
аж ахуйн газрын дарга  
Д.Нэмэхбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн  
хэлтсийн дарга  
А.Нямдаваа- Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга  
Д.Эрдэнэбат-Аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газрын дарга  
Д.Шиваанүрдэв -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга  
С. Дуламсүрэн-Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын  
дарга  
Д.Лхам-Оролмаа- “ӨВ-АЗЗА” ТӨХКомпанийн захирал  
Б.Оюунчимэг -Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга  
Сумын Засаг дарга нар

--oOo--

Аймгийн Засаг даргын 2019 оны 07  
дугаар сарын 29-ны өдрийн АХД дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 2019-2050 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ  
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцаж хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4
<b>Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар</b>			
1.	Сум бүр өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулан, бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж тайланг сар бүрийн 15-ны дотор ХХААГазарт ирүүлэх	8 дугаар сараас	Сумдын ЗДТГазар
2.	Өвөлжилтийн бэлтгэл ажлын явц байдалтай танилцаж, эрчимжүүлэх талаар сумдын удирдлагууд оролцсон шуурхай зөвлөгөөн зохион байгуулах	9 дүгээр сард	Аймгийн ЗДТГазар, ХХААГазар
3.	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллан, шаардлагатай арга хэмжээг холбогдох яам, агентлаг, газруудтай хамтран хэрэгжүүлэх	2019-2020 онд	Аймаг сумдын ЗДТГазар, ажлын хэсэг, холбогдох байгууллагууд
4.	Өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, эрчимжүүлэх ажлыг багийн ИНХурлаар хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авч ажиллах	8,9,10 дугаар сард	Сумдын ажлын хэсэг
5.	Сум бүрт тогтоож өгсөн /аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2009 оны 96 дугаар тогтоол/ сум дундын отрын бүс нутгийн бэлчээрийг хяналтандаа авч, цаг хүндэрсэн үед отроор мал оруулах боломж нөхцлийг бүрдүүлэх ажлыг сумдын удирдлагууд хоорондоо зохицуулж ажиллах	2019-2020 онд	ХХААГазар, сумдын ЗДТГазар
6.	Малчдын хувийн бэлтгэлийг хангахад анхаарч, цаг агаарын мэдээ мэдээллийг тухай бүрд нь авч байх боломжийг бүрдүүлэх, аймаг сумын эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах, шаардлагатай эм, эмнэлгийн болон багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	Тухай бүр	ОБГазар, ЭМГазар, УЦУОШАЛба, Сумдын ЗДТГазар
7.	Өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар хийгдэж байгаа ажил, энэ талаар гарч буй ололт, дутагдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, мэдээлэх	Тухай бүр	Ажлын хэсэг, ХХААГазар
8.	Телевиз, үүрэн телефон, интернэт зэрэг мэдээллийн арга хэлбэрийг ашиглан нийтэд зориулсан цаг агаарын урьдчилан сэргийлэх болон сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг олон нийтэд хугацаа алдалгүй, үнэн бодитой, шуурхай мэдээлж байх	Тухай бүр	Аймаг сумдын ажлын хэсэг, ЗДТГазар

1	2	3	4
9.	Сум бүрийн ажлын хэсэг өвөлжилтийн бэлтгэл хангалтын байдалтай газар дээр нь танилцаж, бэлтгэсэн хадлан, өвс, тэжээл, хужир шүүний мэдээг бодитоор гаргаж мэдээлэх, тайлагнах	Тухай бүр	Сумдын ажлын хэсэг
10.	Зам давааг өвөл хаврын улиралд байнгын нээлттэй байлгах, хүн хүч техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллалах	Тухай бүр	Аймаг сумдын ЗДТГазар, ОБГазар, ТАЗГазар, "АЗЗА" ТӨХК
<b>Хоёр. Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд</b>			
1.	Сум, баг, малчдаас бэлтгэх өвс хадлан, гар тэжээл, давс хужрын доод хэмжээг тухайн бүс нутгийн онцлог, зун зуншлагын байдлыг харгалзан тогтоон өгч биелэлтэд нь хяналт тавьж ажиллах.	08-р сарын 01-ээс 10-р сарын 01 хүртэл	ХХААГазар, Сумдын ЗДТГазар
2.	Өөрийн аймгаас хадлан авах боломж муу байгааг харгалзан өнжсөн өвс, тэжээлийн судалгааг гарган хадгалалт хамгаалалтыг сайжруулан, нөөцийг нэмэгдүүлэх бүхий л талын арга хэмжээг авч ажиллах	08-р сарын 01 10-р сарын 01	Аймгийн ЗДТГ, ХХААГазар, Сумдын ЗДТГазар
3.	Сумдын тэжээл үйлдвэрийн цехүүдийг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тэжээлийн нөөцийг нэмэгдүүлж, малд тэжээл болох бүхий л түүхий эдийг ашиглах, цехүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх, МААЭШХүрээлэнгийн "Долооц" тэжээлийг сум, аймгийн нөөцөд авах боломжийг судлах, мэдээллээр хангаж ажиллах	08-р сарын 25 11-р сарын 30	ХХААГазар, Өмчийн хэлтэс, Сумдын ЗДТГазар
4.	Үр тарианы сүрэл, тэжээлийн ургамлын иш, навч, таана хөмүүл, халгай, лууль зэргийг даршлах, сөлийн хомоол бэлтгэх зэргээр гар тэжээлийн нөөцийг нэмэгдүүлж, малд тэжээл болох бүхий л түүхий эдийг ашиглан нөөцлөх	08-р сарын 10 наас 10-р сарын 10 хүртэл	Сум багийн удирдлага, сумдын ажлын хэсэг, малчид
5	ЗБУлаан, Бат-Өлзий, Хужирт, Уянга, Тарагт зэрэг сумдын хадлан бэлтгэх механикжсан салаануудад өвс хадах талбай олгоход дэмжлэг үзүүлж, сумд хооронд болон зэргэлдээ аймгуудаас талбай эзэмших ажлыг зохион байгуулах. Тэдний бэлтгэсэн өвсийг аймаг, сумын, нөөцөд худалдан авах асуудлыг шийдвэрлэх.	8,9,10-р саруудад	Аймгийн ЗДТГазар, ХХААГазар, холбогдох сумдын ЗДТГазар
<b>Гурав. Бэлчээр хамгаалах, зохистой ашиглах чиглэлээр</b>			
1.	Ургамлын нөмрөгийн судалгаа хийж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргаж сумдад хүргүүлэх	8-9 сард	УЦУОШАЛба, ХХААГазар
2.	Бэлчээрийн хортон мэрэгч оготнотой энгийн механик аргаар 30000 га-д улсын төсвийн хөрөнгөөр тэмцэх ажлыг зохион байгуулах, цаашид малчдын өөрсдийн хүчээр зохион байгуулах ажлыг эхлүүлэх	8-11-р саруудад	ХХААГазар
3.	Сумдууд өөрийн аймгийн бусад сумын нутаг, өөр аймгийн нутаг, аймаг дундын отрын бүсэд мал оруулж өвөлжүүлэх, хаваржих өрх, малын тоог гарган	8-9 дүгээр сард	ХХААГазар, Сумдын ЗДТГазар

1	ХХААГазарт ирүүлэх	2	3	4
4.	Сум, багийн түвшинд өвөлжөө, хаваржааны бэлчээрийг хуваарьтай ашиглах зураглал гаргаж, бэлчээрийг өнжөөх, сэлгэх аргад малчдыг сургах ажил зохион байгуулах	2019-2020 онд байнга	Сумын ЗДТГазар, багийн Засаг дарга нар, сумын газрын даамал, БОХУБайцаагч нар	
<b>Дөрөв. Малын эрүүл мэнд, үржлийн ажлын чиглэлээр</b>				
1	Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх болон ариутгал, халваргүйжүүлэлтэд шаардагдах тарилга эм био бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх, хүртээмжийг сайжруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологийн хугацаанд нь чанартай зохион байгуулах, мал эмнэлэгийн дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг бүрдүүлж, шуурхай удирдлагаар хангаж ажиллах.	2019-2020 онд	ХХААГазар, Сумдын МЭУАҮНэгж	
2	Намрын графит тарилга, туулгалт, угаалга, боловсруулалтыг технологийн хугацаанд нь хийж, шаардлагатай мал сүргийг бүрэн хамруулах, өсвөр охин төлд / хурга, ишиг тугал/ бруцеллезын вакцин тарих.	08-сарын 01 10-р сарын 15	МЭГазар, Сумдын МЭУАҮНэгж	
3	Мал сүрэгт явуулах намрын ангилалтын ажлыг шуурхай зохион байгуулж, хээлтүүлэгч малын хүрэлцээ хангамжийг судлан, стандартад тэнцсэн хээлтүүлэгчээр хангах, дутагдаж байгаа хээлтүүлэгчийг дотоодын цөм сүрэг болон, зохиомол хээлтүүлгийн үр дүнд гарсан өсвөр хээлтүүлэгчээр нөхөн хангах арга хэмжээ авах	2019-2020 онд	Сумдын ЗДТГазар, ХХААГазар	
4	Малын хашаа саравчийг засаж сэлбэх, шинээр барих замаар хүрэлцээ хангамжийг сайжруулах, шавж дулаалах, хэвтэр бууцыг хатаах, хөрсөнг ховхлох, ариутгаж халдваргүйжүүлэх	08-р сар 15 наас 10-р сарын 15	ХХААГазар, Сумын ЗДТГазар, Сумдын МЭНэгж	
5	Хээлтүүлгийн ажлыг цаг агаарын төлөв, малын тарга хүч, хүн хүчний нөөцөд тохируулан бодлоготой зохион байгуулж, хуц,ухныг өвөлд ялгаж тэжээх бэлтгэл хангах.	10 дугаар сард	Сумын ЗДТГазар, малчид	
<b>Тав. Мал мах борлуулах ажлын хүрээнд</b>				
1.	2019-2020 оны махны унийг тогтворжуулах зорилгоор экспортод гаргах"ӨВ-Эко Мийт", "Дэлхийн хүнс"ХХК-д мах экспортлох зөвшөөрөл, эрх олгох ажлыг зохион байгуулж, аттестатчилалд хамруулах, гадаадад гаргах махны хэмжээг тодорхой болгох арга хэмжээ авах, Арвайхээр суманд амьд малын зах нээн ажиллуулах, мал, мах бэлтгэх ААНэгж, байгууллагатай гэрээ байгуулах	2019-2020 онд	Аймгийн ЗДТГазар ХХААГазар Арвайхээр сумын ЗДТГазар	
2.	Отор нүүдлийг цаг алдалгүй хийж, малдаа тарга хүч авхуулан тарга хүчний үзлэгийг хийж мал сүргийнхээ дундаас доош тарга хүчтэй болон бэлчээрийн	9,10,11-р сард		

1	даацаас хэтэрсэн малыг зах зээлд борлуулах ажлыг зохион байгуулах 2	3	4
3.	Сум бүр зах зээлд борлуулах малын төрөл, тоо, сумын хэмжээнд байгаа мах нөөцлөх зоорины судалгаа, зоорины ашиглалтанд үзлэг хийж үнэлгээ өгөх ажлыг зохин байгуулах, огт зоорь байхгүй бол зооринд хадгалуулах махны захиалга зэргийг үнэн зөв гаргаж 2019 оны 9 дүгээр сард багтаан ХХААГазарт ирүүлэх	09 дүгээр сард	Сумын ажлын хэсэг, сумын ЗДТГазар
<b>Зургаа. Ургац хураалтын бэлтгэл ажлын талаар</b>			
1	Аймгийн ургацын штаб ажиллуулж ургац хураалтын бэлтгэл ажлыг урьдчилан сайтар хангаж, технологийн хугацаанд нь хаягдалгүй хураан авах, ургац хураагаагүй талбайд мал оруулахгүй байх талаар тариаланчид, малчдын хариуцлагыг өндөржүүлж, нутаг усыг зохицуулах, ургац хураалтын техник засварын ажлыг хийлгэж, үтрэм, агуулах, зоорь засварлах ажлыг шуурхай зохион байгуулах, хяналт тавих.	8-рсарын 01 11-р сарын 01	ХХААГазар, МХГазар Хархорин сумын Засаг дарга, Хархорин сумын үр тарианы аж ахуй нэгжүүд
2	Төмсний үрийн талбайд хянан баталгаа хийх, үрийн нөөц бүрдүүлэх, уринш боловсруулалтыг хүлээн авч акт материалыг бүрдүүлэх, дүгнэлт гаргах.	08-р сарын 28 09-р сарын 25	ХХААГазар, МХГазар
3	Бүх тарималд ургац тогтоолт хийж, актыг ХХААХҮЯаманд хүргүүлэх	09-р сарын 01 ний дотор	ХХААГазар, МХГазар